

<https://doi.org/10.5564/spej.v46i37.2566>

**Хөрш орнуудын хөгжлийн бодлогын онцлог: ололт, амжилт,
сорилт, бэрхшээл**

**Distinctive features, achievements, and challenges of development policies
of neighboring countries**

Омбоосүрэнгийн Эрдэнэчимэг¹

*Доктор (Ph.D), дэд профессор, ЭШАА
Шинжлэх Ухааны Академийн
Философийн хүрээлэн
Улс төр, эрх зүйн салбар
erdenechimegomboosuren@gmail.com*

Erdenechimeg Omboosuren

*Doctor (Ph.D), associated professor
Senior researcher, Department of Political
Sciences & Legal Studies,
Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
erdenechimegomboosuren@gmail.com*

Хураангуй

1990 онд Зөвлөлт Холбоот Улс задран унаснаар түүний бүрэлдэхүүнд байсан улс орнууд болон социалист системд байсан улс орнууд олон сорилт, бэрхшээлүүдтэй нүүр тулсан. Эдгээр улс орнууд хүн төрөлхтний үнэт зүйл болсон хүний эрх, эрх чөлөө, ардчиллыг дээдлэх, зах зээлийн эдийн засгийг тууштай баримтлах замыг сонгож өнөөдрийг хүртэл энэ чиг баримжаагаар 30 гаруй жил хөгжиж байна. Тиймээс ОХУ, Казакстан, Өмнөд Солонгос, Монгол улсуудын хөгжлийн онцлог юу байв, ямар амжилтанд хүрсэн, ямар сорилт бэрхшээл тулгарч буйг харьцуулан дүгнэх зорилгоор эл өгүүллийг бичсэн болно. Өгүүллийн харьцуулсан судалгаанаас харахад улс төрийн болон хөгжлийн бодлого хэдий чинээ тогтвортой байх нь төдий чинээ улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил үр дүнтэй байдгийг харуулж байна.

Түлхүүр үг: Нийгэм-эдийн засгийн бодлого, инфляцийн түвшин, ажилгүйдлийн түвшин, авилгын индекс, ДНБ-ний, бодлого, Монгол, ОХУ, Казакстан, Өмнөд Солонгос.

Abstract

With the collapse of the Soviet Union in 1990, its member states and countries with socialist regime faced many challenges and obstacles.

Countries have developed differently for more than 30 years, choosing to uphold human values, freedoms, democracy, and a market economy.

This is the reason the paper studies how Russia, Kazakhstan, and Mongolia have developed, what challenges they have overcome, and what they have achieved. In the case of Russia and Kazakhstan, the social and economic results have been relatively high due to relatively stable development policies and policies.

The above research shows the higher is the sustainability of political and development policies, the higher success it shows for socio-economic development.

Keywords: socio-economic policy, inflation rate, unemployment rate, corruption index, GDP, concept, Mongolia, Russian Federation, Kazakhstan, South Korea.

¹© Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

I. Оршил

Монгол Улсын хөгжил өөрийн нь оршин буй бүс нутаг болох Ази тивийн улс орнуудын хөгжлийн түүх, нөхцөл байдалтай салшгүй холбоотой явж ирсэн түүхэн уламжлалтай.

Бид 1990 онд хүн төрөлхтний үнэт зүйлс болсон хүний эрх, эрх чөлөө, ардчиллыг дээдлэх, зах зээлийн эдийн засгийг тууштай баримтлах замыг сонгож өнөөдрийг хүртэл энэ чиг баримжаагаар 30 гаруй жил хөгжиж байна. Харин бидэнтэй хаяа залган мөнхөд оршдог хөрш зэргэлдээ улс орнууд, азийн амжилттай хөгжиж буй улс орнууд шилжилтийн үеийн ороо бусгаа хүнд үеийг хэрхэн давж туулав, ямар бодлого хэрэгжүүлэв, түүнийхээ үр дүнд ямар амжилтанд хүрэв, ямар сорилт бэрхшээл тулгарав, бид ямар сургамж авах хэрэгтэй вэ? гэдгийг судалж харьцуулан үнэлж дүгнэх зорилгоор энэ өгүүллийг бичиж байна. Өөрөөр хэлбэл ОХУ, Казакстан, Өмнөд Солонгос зэрэг улс орнуудын хөгжлийн онцлогоос туршлага дууриалал авах, бусдын хүртээл болгохыг зорьсон юм.

Өнөөдрийг хүртэл дэлхийн улс орнуудын хөгжлийн талаарх тодорхой нэгдсэн жор, дүрэм журам бий болоогүй байгаа. Тухайлбал: Скандиновын болон хойд Европын улс орнууд нийгмийн баримжаатай, төрийн зохицуулалттай хөгжлийн загварыг гол зарчмаа болгосон, АНУ болон баруун Европын өндөр хөгжилтэй улс орнууд либерал капитализмыг гол концепци болгосон, Дорно дахины өндөр хөгжилтэй Япон, Солонго, Сингапур зэрэг Азийн улс орнууд уламжлалт нийгмийн хөрс суурин дээр орчин үеийн ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцааны олотыг өөрийн нөхцөлд зохистой хэлбэрээр суулгаж хөгжсөн, ОХУ тэргүүтэй хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнууд хуучин улс төрийн системийн номенклатуртаа бага зэргийн өнгөц засвар оруулсан дүр эсгээд, эдийн засгаа зах зээлийн харилцаагаар явуулж байгаа, манай өмнөд хөрш улс төрийн ситем нь хуучин тоталитар хэв маягаар, эдийн засаг нь бүрэн зах зээлд шилжин хөгжиж байна. Энэ бол олон талт хөгжлийн бодлого хандлагын үр дүн гэж хардаг.

Ингэхдээ хөгжлийн алтан гурвалжин болох нийгмийн тэгш байдал, эдийн засгийн өсөлт, хүрээлэн буй орчны хамгаалалт зэрэг асуудлуудыг ямагт анхаарлынхаа төвд тэнцвэртэй байлгахыг зорих шаардлагатай.

Богино хугацаанд улс орноо зөв замаар хөгжүүлж, буурай хөгжилтэй улс орноос хөгжингүй хөгжилтэй болгож чадсан орнууд нэн тэргүүнд урт, дунд, богино хугацааны нэгдсэн бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах, хянах механизмыг тодорхой болгон ажиллажээ. Зөв стратеги, төлөвлөлтийн систем нь ажлын байр шинээр бий болгох, иргэдээ орон сууцаар хангах, хүрээлэн буй орчноо хамгаалах, байгалийн баялгийн хишгийг ард түмэндээ тэгш хүртээмжтэй хүргэх, шударга хуваарилалтын систем бий болгох зэргээр ард иргэдийнхээ амьдралд эерэг өөрчлөлтүүдийг авчирахад чиглэгддэг. Өөрөөр хэлбэл төлөвлөлтийн гол үр дүн нь “тогтвортой хөгжил” байдаг. Энэ л зорилго зорилтыг хэрэгжүүлэхээр улс орон бүр өөр өөрсдийн жамаар хөгжиж буй билээ.

II. Судалгааны арга зүй

Энэ өгүүллийг бичихийн тулд баримт бичгийн судалгааны арга зүйг голчлон ашиглав. Жишээлбэл: Өндөр хөгжилтэй улс орнуудын хөгжлийн бодлого төлөвлөлт, Европын улс орнуудын хөгжлийн загварыг харьцуулсан судалгаа, Азийн түргэн хөгжсөн улс орнуудын болон Сингапурын хөгжлийн онцлог, ОХУ болон Казакстан улсын хөгжлийн тухай, Үндэсний хөгжлийн газраас гаргасан ном товхимол, өгүүлэл, нийтлэл, УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Судалгааны төвөөс гаргасан цуврал материалууд, олон улсын байгууллагуудын гаргасан статистик тоо баримт, шинжилгээ зэрэг олон бичиг баримтууд, ном товхимолуудтай танилцаж харицуулсан дүн шинжилгээ хийж, нэгтгэн дүгнэж ажиллав. Дээрх мэдээллийн эх сурвалжууд нь найдвартай эх үүсвэр байсныг нотолж байна. Мөн дотоод гадаадын статистик тоон мэдээллийг ашиглан дүн шинжилгээ хийх аргыг хэрэглэсэн болно.

III. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

Өгүүллийн энэ хэсэгтээ улс орнуудын хөгжлийн бодлогын онцлог, үр дүнг харьцуулан авч үзэв.

А. ОХУ-ын хөгжлийн онцлог: 1990 онд ЗХУ задран унаснаар Шинэ Орос улсын түүх эхэлдэг. Тухайн үеийн Орос оронд өрнөсөн реформыг өөр өөрийн концепци бодлогоор явуулах хөтөлбөрүүдийг Григорий Явлинский, Егор Гайдар нарын зэрэг олон хүн санаачилан хэрэгжүүлсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүйгээр барахгүй олон хүндрэл бэрхшээлүүдтэй тулгарч байсан.

Харин 1990 оны төгсгөлд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин болсноор төрийг бэхжүүлэх реформ эрчимтэй хийгдэж, ТУХН-ын орнуудын интеграцчилал идэвхижсэн. ОХУ-ын Ерөнхийлөгч шинэ албан тушаалдаа томилогдсоны дараа Холбооны хуралд хандаж хэлсэн үгэндээ “Улсынхаа нийгэм- эдийн засгийг хөгжүүлэх дунд хугацааны үзэл баримтлалын талаар нэг хэсэг болгон оруулах ба Засгийн газар түүнд үндэслэн Нийгэм-эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр боловсруулж ОХУ-ын Холбооны зөвлөл, Төрийн Думд албан ёсоор танилцуулна гэжээ[1].

Ингэж дотооддоо улс орноо хөгжүүлэх хөгжлийн бодлого стратегиа тодорхой болгон, тэргүүлэх чиглэлүүддээ чухалчлан анхаарч ажиллахын зэрэгцээ тодорхой салбарын чиглэлээр стратегийн зорилтуудаа тодорхойлон ажилласан байна. Тухайлбал: 2005 оноос “Нийгмийн” гэсэн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлжээ. Энэ хөтөлбөрийн хүрээнд Эрүүлийг хамгаалах, Боловсрол, ХАА, Орон сууцны асуудлуудыг хамруулан нийт 5 тэрбум доллар зарцуулахаар төлөвлөсөн байна[2]. Орон сууцны хөтөлбөрт нийт 21,9 млрд.руб, Эрүүл мэндийн хөтөлбөрт 145 тэрбум рубль зарцуулахаар тусгасан байна. Үүнээс 30 тэрбумийг хэсгийн эмч, сувилагч, түргэн тусламжийн ажилтнуудын цалин нэмэхэд, 30 тэрбумийг анхны тусламжийн оношилгоо, эмчилгээний 15 төв шинээр барих буюу хуучныг шинэчлэхэд мөн 12000 түргэн тусламжийн машин худалдаж авахаар тусгасан байна. “ХАА-н үйлдвэрлэл хөгжил” үндэсний хөтөлбөрт МАА-н хөгжил, ХАА-н жижиг дунд үйлдвэрийн хөгжлийг голчлон анхаарчээ. “Боловсрол” үндэсний хөтөлбөрт багш нарын болон анги удирдсан багш нар, эрдэмтэд, сурган хүмүүжүүлэгчдийн цалин нэмэх, Москва, Санкт Петербург хотуудад дэлхийн стандарт хангасан бизнес сургууль байгуулах, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх зэрэг маш олон ажлуудыг

хийхээр төлөвлөсөн нь бүрэн биелсэн байна. Ж: Эмч нарын цалинг 300 ам.доллараас дээш, сувилагч нарын цалинг 180 ам.доллараас дээш, эрдэм шинжилгээний ажилтнуудын цалинг 1000 ам \$-с дээш болгосон байна.


2006 онд “ОХУ-ын нийгэм-эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”-ыг боловсруулж 2008 онд баталсан аж. ОХУ дэлхийн анхдагч эрчим хүчний 10 орчим хувийг үйлдвэрлэдэг учраас Ерөнхийлөгч В.Путин “Эдийн засгаа шинэчлэх тухай яривал эрчим хүчний шинэчлэл нэн тэргүүнд байх ёстой” гэж хэлсэн байдаг. 2009 онд ОХУ-ын “Эрчим хүчний стратеги – 2030” баримт бичгийг батлан хэрэгжүүлжээ. Энэхүү стратегийг хэрэгжүүлснээр ОХУ экспортын чиглэлийг нэмэгдүүлэх замаар олон улсын эрчим хүчний аюулгүй байдлын системийг бүрдүүлэхэд боломжтой хэмжээнд оролцох, улсын эдийн засаг нь нефть хийгээс бүрэн хамааралтай байдлыг багасгах зорилго тавьжээ.

Ингэж улс орны нийгэм, эдийн засаг, санхүүг бэхжүүлэх олон талт арга хэмжээ авч ажилласны үр дүнд нэг хүнд ногдох ДНБ 1999 онд 5914\$, 2000 онд 6825\$, 2001 онд 7361\$, 2016 онд 8704\$, 2017 онд 10720\$, 2018 онд 11287\$, 2019 онд 11497\$, 2020 онд 10126\$, 2021 онд 12172,8\$[3] болж өссөн байна. Өөрөөр хэлбэл 1999 оноос 2021 он хүртэлх 22 жилийн хугацаанд нэг хүнд ногдох ДНБ бараг 2 дахин өссөн байна.

Инфляцийн түвшин 1999 онд 72,4%, 2000 онд 37,7%, 2001 онд 16,5% байсан бол 2016 онд 2,844%, 2017 онд 5,035%, 2018 онд 9,998%, 2019 онд 3,084%, 2020 онд 0,896%[4] болж буурсан ба 2022 онд 16,3% болж өссөн байна. Инфляцийн энэ өсөлт нь ОХУ, Украйнд цэргийн тусгай ажиллагаа явуулснаас ЕХ, АНУ зэрэг барууны орнууд ОХУ-ын эдийн засагт олон төрлийн хориг тавьсан нь тус улсын эдийн засагт олон сөрөг үр дүн авчирсантай холбоотой гэж үзэж байна. Мөн эдийн засгийн хүчин чадлаараа ОХУ 2019, 2020 онуудад дэлхийд 11 дүгээр байранд орж, ОХУ-ын Gini индекс: 2016 онд 36,8, 2017 онд 37,2, 2018 онд 37,5 хүрсэн байна.

Ажилгүйдлийн түвшин 2000 онд 10,0% байсан бол 2018 онд 4,85%, 2019 онд 4,5%, 2020 онд 5,59% болж тус тус буурсан байна. Мөн ОХУ-д ядуурлын түвшин 1990 онд 30,0%, 1995 онд 24,8%, 2000 онд 29,0%, 2005 онд 17,8%, 2010 онд 12,5%, 2015 онд 13,3%, 2020 онд 13,5% болж 2,3 дахин буурсан үзүүлэлттэй байна[5].

Зураг 1. ОХУ-ын 1990-2020 оны үеийн ядуурлын түвшин



ОХУ-д нийгэм, эдийн засгийн тууштай, тогтвортой бодлогын үр дүнд дээрх эерэг олон үр дүнгүүд гарсан ч шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан олон асуудал байсаар байна. Тухайлбал, Авлига, хээл хахууль газар авсан, хууль хэрэгжүүлэх тогтолцоо шударга бус, нийгмийн материал, баялгийн хуваарилалт тэгш бус, нийгэм, эдийн засаг дахь улс төрийн оролцоо нөлөөлөл их гэх мэт олон сөрөг асуудлууд байгаа нь олон улсын байгууллагуудын судалгаа шинжилгээгээр харагдаж байна.

Жишээ нь: ОХУ авилгын асуудлаар Трансперэнси интернэшнл Олон улсын байгууллагын гаргасан судалгаагаар дэлхийн 180 улс орноос сүүлийн 10 жилд голдуу 100 гаран орны дараа орсон судалгаа байна.

Зураг 2. ОХУ-ын авилгын индекс (100 оноос тооцсон үнэлгээ)



2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
(113)	(127)	(136)	(119)	(131)	(135)	(100)	(137)	(129)

Тухайлбал 2012 онд 28 оноо авч 113 дугаар байранд орж байсан бол 2020 онд 30 оноо авч 129 дүгээр байрт [6] орж авлига ерөнхийдөө байр сууриа бат хамгаалсан дүр зураг харагдаж байна. “Freedom House” байгууллагын 2020 оны хэвлэлийн эрх чөлөөний индексээр ОХУ 48,71 оноо авч 180 улс орноос 150 дугаар[7] байрт, мөн ардчиллын индексээр 3.31 оноо авч авторитари дэглэмтэй улс[8] гэж үнэлэгдсэн байна. Эдгээр үзүүлэлт нь иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зөрчигддөг, улс төрийн эрх чөлөө болон сонголт хязгаарлагдмал гэж ойлгогдож байна.

Дээрх ОУБ-уудын хийсэн судалгаа дүгнэлтээс харахад ОХУ-д шударга сонгууль, улс төрийн нөлөөллөөс хараат бус хууль, шүүхийн тогтолцоо, чөлөөт хэвлэл мэдээлэл, авилгын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ учир дутагдалтай байгаа нь харагдаж байна. Мөн нийгмийн баялгийн хуваарилалт тэгш бус, бизнесийн үйл ажиллагаанд төр хутгалдан ордог учраас төртэй холбогдохгүйгээр бизнесийн үр дүн гарахгүй, хамгийн ашигтай бизнесийг төр хийх ёстой гэсэн буруу хандлага газар авсныг илтгэж байна.

2022 оны 2 дугаар сарын 24-нд ОХУ, Украинд цэргийн ажиллагаа явуулж эхэлсэн. Үүнтэй уялдан Европын холбоо, түүний гишүүн улс орнууд, АНУ-аас ОХУ-д хязгааргүй олон хориг арга хэмжээг тавьсан нь аль аль улс орнуудын эдийн засаг, санхүүд нөхөж баршгүй сөрөг үр дагаваруудыг авчирч, улс орнуудад эдийн засгийн хямрал үүсэж цаашид улам даамжрах хандлагатай байна.

Б. Казахстан Улсын хөгжлийн онцлог: Казахстан улс ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнуудын нэг бөгөөд 1990-ээд оны зааг үеэр

Холбооны Бүгд Найрамдах улсуудын нэгэн адил мухардмал байдалд орсон. Тухайн үеийн Казахстан улсын Ерөнхийлөгч асан Н.Назарбаев энэ түүхэн эгзэгтэй үед улс орноо хэрхэн зөв хөгжүүлэх тухай эрэлд мордон, дэлхийн хэмжээний хүмүүс болох Маргерат Тетчер, Франсуа Миттеран, Гельмут Коль, Жорж Буш (эцэг), Ли Куан Ю, П Иоанн Павел нартай уулзан учирч, санал бодлыг нь сонсож эхэлсэн тухайгаа өөрийнхөө номондоо бичсэн байна. Тэр ”Бид тийм хүмүүсийн тусламжтайгаар даяарчилж буй ертөнцийг үзэх үзлээ боловсруулсан. Бид яриа хэлэлцээнд үргэлж нээлттэй байж шинэ соргог үзэл санааг тусган авахад бэлэн, бидний талаарх шүүмжлэлийг зохих ёсоор тунгаан хүлээн авдаг байсан”[9] гэж дурьджээ.

1992 оны эхээр боловсруулсан “Казахстаныг тусгаар тогтносон улс болгон хөгжүүлэх стратеги” нь улсаа хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөний анхных нь байсан. Энэ стратегидаа: Казахстан орон төлөвлөгөөт эдийн засгаас, зах зээлийн эдийн засагт, захиргаадалтын дэглэмээс чөлөөт дэглэмд шилжинэ гэж маш тодорхой заасан байна.

Дараа нь 1997 оны эцсээр Ерөнхийлөгч Н.Назарбаев “Казахстан – 2030: Бүх Казахстанчуудын хөгжил цэцэглэлт, аюулгүй байдал” гэсэн илгээлтийг бүх ард түмэндээ хандан гаргажээ. Энэ нь тусгаар тогтносон Казахстан улс түүхэндээ анх удаа богино болон урт хугацаанд хөгжлийн стратегиа тодорхойлсон явдал байв. Илгээлтэд улс орны эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, хөгжлийн ерөнхий чиг хандлагадаа нарийвчилсан дүн шинжилгээ өгчээ. Улс орны хувьд хамгийн чухал нь аюулгүй байдал, улс төрийн тогтвортой байдал, мэргэжлийн төр байгуулах гэжээ. Үүний тулд зах зээлийн эдийн засагт тулгуурласан эдийн засгийн өсөлт, эрүүл мэнд, боловсрол, эрчим хүчний нөөц, дэд бүтцийн хөгжлийн асуудлыг нэн тэргүүнд тавих шаардлагатай гэж үзжээ. Мөн улс орныхоо эдийн засгийн ололт амжилтыг илүү их анхаарч сайжруулахын зэрэгцээ хүн ардынхаа эв нэгдлийг сахин хамгаалах, нийгмийн сэтгэл зүйг зөв чиглүүлэх, улс орныхоо хөгжлийн ирээдүйг хамтдаа бүтээхэд уриалсан баримт бичиг болсон байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд “Аж үйлдвэр – инновацийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд шинэ техник, технологи дээр суурилсан автомашин, зүтгүүр, вагон, нисдэг тэрэг болон бусад бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 1000 гаруй шинэ үйлдвэр, аж ахуйн газрууд байгуулагдсан” байна. Мөн улсын зам, тээврийн дэд бүтэц ч хурдтай шинэчлэгдсэн ба сүүлийн 25 жилийн хугацаанд 10 000 км авто зам, 2500 км шинэ төмөр зам баригдсан бол ойрын жилүүдэд 8000 км автозамын сүлжээг шинэчлэх зорилго тавьсан ажээ. Казахстаны иргэн бүрийг боломжийн үнэ өртөг бүхий орон сууцаар хангах боломжтой “Орон сууц 2020” хөтөлбөр 2011 оноос хэрэгжсэн ажээ[10].

Түүнчлэн эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтийг эрчимтэй явуулахын зэрэгцээ нийгмийн хөгжлийг орхигдуулахгүй байх зорилго тавьж онцгой анхаарч ажиллажээ. 2014 оны 4 дүгээр сарын 24-ны Засгийн газрын тогтоолоор “Казахстан Улсын нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл – 2030” баримт бичгийг баталж иргэдийн амьжиргааны түвшин, хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, боловсролын системийн өрсөлдөх чадварыг сайжруулах, чадамжтай эрүүл мэндийн системийг хөгжүүлэх зэрэг зорилго тавьсан аж. Эдгээр ажлын үр дүнд 1991 онтой харьцуулахад иргэдийн дундаж цалин 17 дахин, тэтгэвэр 10 дахин

өссөн байна. Мөн Казакстан Улсын хүн амын дундаж наслалт 64 байсан бол 72 болсон ба улсын хүн ам 16,7 сая байснаа 2020 онд 18,9 сая болж өссөн байна.


Хүний хөгжлийн индексээр /эрүүл мэнд ба урт наслалт, боловсрол ба амьдралын түвшний үзүүлэлт/ өнгөрсөн жил дэлхийн 189 орноос 51 дүгээр байр эзэлсэн байна. 2020 онд улсын төсвийн 26%-г нийгмийн хангамж, тусламжинд зориулсан байна[11].

Казакстан улсын тусгаар тогтнолын 20 жилийн ойн үеэр дэлхийн 150 гаруй улс оронтой дипломат харилцаа тогтоосон, эдийн засаг нь 20 дахин өссөн, нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 2013 оны байдлаар 13600 ам.доллар буюу зүүн Европын улс орны түвшинд хүрч, 1,3 сая үйлдвэрлэгч буюу баялаг бүтээгч нь үндэсний баялагийн ¼-ийг үйлдвэрлэсэн орон болжээ. Өөрөөр хэлбэл дэлхийн эдийн засгийн өрсөлдөх чадвартай шилдэг 50 улсын эгнээнд багтан орж, Дэлхийн банкны “Doing Business” рейтингээр 35 дугаар байранд орсон амжилт үзүүлжээ. Мөн дэлхийн хамгийн эрчимтэй хөгжиж байгаа улсын нэгээр дэвшин орсон байна.

Ийм учраас Казакстан Улсын хөгжлийн хүрсэн түвшин, үр дүн, хөгжлийн онцлогийг сонирхохгүй байхын аргагүй юм. Тухайлбал, Казакстан Улсын нэг хүнд ноогдох ДНБ: 1993 онд 1429\$ байсан бол 2013 онд 13600\$, 2016 онд 7714\$, 2017 онд 9247\$, 2018 онд 9812\$, 2019 онд 9812\$, 2020 онд 9122\$, 2021 онд 10041.5\$ болж 1993 онтой харьцуулахад бараг 7 дахин өссөн байна. Өөрөөр хэлбэл нэг хүнд ногдох ДНБ-нээр Зүүн Европын улс орнуудын түвшинд хүрсэн ажээ.

Инфляци: 1995 онд 60.39% байсан бол 2000 онд 10.0%, 2005 онд 7.87%, 2010 онд 7.97%, 2015 онд 13.53%, 2020 онд 6.37%, 2021 онд 10.6%-тай байна. Үүний зэрэгцээ эдийн засгийн хүчин чадлаараа дэлхийд 54 дүгээр байрт жагссан сайн үзүүлэлтүүд байгаа боловч шийдвэрлэх шаардлагатай маш олон асуудлууд байсныг саяхан 2022 оны эхээр Казакстан улсад болсон үйл явдлууд харууллаа. “The Economist” сэтгүүлийн 2020 оны үзүүлэлтээр Казакстан улс ардчиллын индексээр 3,14 оноотой Авторитар дэглэмтэй улс[12] орны тоонд орж 128 дугаар байр эзэлсэн байна. Мөн хэвлэлийн эрх чөлөөний индексээр Фрийдом хаус ОУБ-ын шалгаруулалтаар 2021 онд 50.28 оноо авч 155 дугаар байр[13] эзэлсэн байна. Трансперэнси интернэшнл Олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг авилгын индексээр Казакстан Улс 2012-2020 онуудад 9 жилийн хугацаанд 26-38 оноо авч 94-131 дүгээр байр тус тус эзэлсэн байна.

Зураг 3. Казакстан улсын авилгын индекс



Эдгээр олон улсын байгууллагуудын гаргасан судалгаа, дүгнэлтээс харахад Казахстан Улсад хэвлэл мэдээлэл, иргэдийн улс төрийн эрх чөлөө тийм ч чөлөөтэй биш байдал ажиглагдаж байна. Мөн авлигын индекс өндөр хэвээр буюу дэлхийн улс орнуудын түвшинд голдуу 100-с хойш байранд орж байгаа нь авилгал харьцангуй их байгааг харуулж байна.

Дээрх судалгаануудын үнэлгээ дүгнэлтээс харахад шинэ казахстан улсын нийгэм, эдийн засгийн хөгжил харьцангуй амжилтанд хүрсэн ч нийгмийн баялгийн хуваарилалт тэгш бус, нэг хүнийг тахин шүтэх үзэл хир хэмжээнээсээ хэтэрсэн, өөрөөр хэлбэл шинэ тутам улсын хөгжил цэцэглэлтийн үр өгөөж, зах зээлийн эдийн засгийн үр шимийг зөвхөн дээгүүр албан тушаалтнууд, тэднийг тойрон хүрээлэгчид, олигархууд хүртэж, зөвхөн дээдсийн эрх ашгийг хамгаалсан бодлого руу гулсаж орсон өрөөсгөл дүр зураг харагдаж байна. Өөрөөр хэлбэл бодлого, зорилгын хэрэгжилт хөгжлийн явцад гажууджээ гэж үзэж болохоор байна.

В. Бүгд Найрамдах Солонгос Улсын хөгжлийн онцлог: 1950-иад оны дайны дараа ХАА эрхэлдэг ядуу буурай орон байсан Өмнөд Солонгос Улсын эдийн засаг 1962 оноос огцом хөгжиж, 40 жил хүрэхгүй хугацаанд “Хан мөрний гайхамшиг” хэмээн алдаршин бахдам амжилт үзүүлсэн ажээ.

Солонгос Улс, улс орноо хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр бий болгоход 1950-иад оны үеэс ихээхэн анхаарч ажилласан. Тэд гадны зээл тусламжаас илүү өөрийн хүч бололцоогоо ашиглаж, эдийн засаг дахь төрийн оролцоо ихтэй байх хэлбэрийг илүүд үзэж чухалчилсан нь Солонгос Улсын хөгжлийн бодит суурийг тавихад гол нөлөө үзүүлсэн гэж үздэг ажээ. Улс үндэстний хөгжлийн өсөлт бууралт нь тухайн улс орны баримталж буй бодлоготой шууд холбоотой байдаг.

Америкийн эдийн засагч М.Олсон “*Үндэстний өсөлт, уналт, эдийн засгийн өсөлт, зогсонги байдал болон нийгмийн тэсвэр*” номондоо улс төр, бизнесийн цөөн хэдэн бүлэглэл монополь байдлаа хадгалан, явцуу ашиг сонирхлынхоо төлөө зөвхөн өөрт ашигтай хууль журам батлуулах хандлагатай байдаг нь нийгмийн үр ашиг, бүтээмжийг бууруулдаг гэж нотолсон байдаг[14]. Харин Өмнөд Солонгосын хувьд эдийн засгийн бодлого нь ийм сонирхолын бүлгээс хамаардаггүй байсан нь өндөр хурдацтай хөгжихөд чухал нөлөөлсөн гэж үздэг ажээ.

Мөн 1961 онд эдийн засгийн төлөвлөлтийн хороог байгуулж улс орноо тав таван жилээр хөгжүүлэх хэтийн оновчтой төлөвлөгөө гарган ажилласан. Солонгос Улсыг хөгжүүлэх анхдугаар 5 жилийн төлөвлөгөө 1962 онд баталсан ба энэ нь Солонгос Улсын эдийн засгийн хөгжлийн суурь, стратегийн баримт бичиг болохын зэрэгцээ, экспортод чиглэсэн үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага болсон ажээ. 1961 онд Солонгос Улс ядуу буурай, эмх замбараагүй, авилгалд идэгдсэн, кимчинээс өөр үйлдвэргүй буурай орон байсан.

Энэ үед Герман улсаас авсан зээл тусламжаар, хөдөөгийн ядуу суурингуудыг өөрчлөх зорилгоор 40 аж үйлдвэрийн комплекс байгуулж оймс, цамц, өмдний гэх мэт хөнгөн үйлдвэрүүдийг байгуулжээ. Эдгээр 40 аж үйлдвэрийн цогцолборууд нь хөгжин дэвшиж бүс нутгийн хөгжлийн төвүүд болсон. Өнөөдөр эдгээр төвүүдээ мэдлэгийн АҮ-ийн төвүүд болгон өөрчлөн хөгжүүлжээ.

Солонгос улс эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөөг 1962-1992 он хүртэл нийт 7 удаа хэрэгжүүлсэн, тэдгээр төлөвлөгөөнүүд нь тус бүрдээ Солонгосын эдийн засагт аж үйлдвэржих, экспортыг дэмжих зэрэг тодорхой зорилгод чиглэгдэж байсан. Эхний 3 үе шат нь 1962-1976 оны хооронд хэрэгжсэн ба үндсэн зорилго нь үндэсний үйлдвэрийн бүтцийг бий болгох, тус бүтцээ улам сайжруулан хөгжүүлэх, улмаар экспортод чиглэсэн үйлдвэрүүдийг бий болгоход чиглүүлэн амжилттай ажилласан байна. Харин дараагийн 4 таван жилийн төлөвлөгөөгөөр эрчимжсэн технологийн үйлдвэрлэл, чадварлаг хүний нөөц бэлтгэх, өндөр технологийн салбарыг дэмжихэд чиглэгдэн ажиллажээ.

Дашрамд хэлэхэд Засгийн газраас улс орноо нуруундаа авч явж чадах үндэсний хэмжээний томоохон компаниудад бага хүүтэй зээл өгч, дэлхийд өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх үүрэг даалгавар өгч, тэднийг дэмжих бодлого барьж ажилласны үр дүнд тэр компаниуд дэлхийн түвшинд хүрч ажиллаж чадсан байна. Мөн импортын бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх чиглэлийг баримталж аажим аажмаар ахиц гарч өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээ ерөнхийдөө дотооддоо үйлдвэрлэдэг болсон байна.


БНСУ-ын хүрсэн хөгжлийн амжилт бол гайхамшиг гэж бүх дэлхий шагшин магтдаг. Тухайлбал: Нэг хүнд ноогдох ДНБ: 1960 онд 158.2\$, 1970 онд 279.3\$; 1980 онд 1715.4\$; 1990 онд 6610\$; 2000 онд 122574, 2010 онд 23087.2\$; 2016 онд 29288.87\$; 2017 онд 31616.84\$; 2018 онд 33422.94\$; 2019 онд 31936.80\$; 2020 онд 31631.47\$[15] хүрч өндөр хөгжилтэй улс орнуудын түвшинд аль эрт хүрсэн ажээ. Энэ судалгааны дүнгээс харахад БНСУ-ын эдийн засаг 1980 оноос улам эрчимтэй хөгжиж 10 жил тутамд 1 хүнд ноогдох ДНБ 2 дахин өссөн амжилт харагдаж байна.

Инфляци: 2016 онд 1.986; 2017 онд 2.223; 2018 онд 0.483; 2019 онд 0.839; 2020 онд 1.313; 2021 онд 2.3% байна.

“The Economist” сэтгүүлийн 2020 оны үзүүлэлтээр Солонгос Улс ардчиллын индексээр 8,01 оноотой бүрэн ардчилсан улсын тоонд багтаж дэлхийн улс орнуудын 23 дугаарт жагссан байна[16]. Мөн тухайн улс дахь улс төрийн эрх 33 оноотой, иргэний эрх 50 оноотой, нийт 83 оноогоор иргэний эрх чөлөөтэй гэсэн улсын тоонд байдаг байна. Сайн засаглалын үзүүлэлтээр 2021 онд 60.8 оноотой дэлхийд 27 дугаар байрт орсон байна[17]. Ардчиллын чанараар үнэлбэл 0.83 гэсэн индексээр дэлхийд 20 дугаарт жагсжээ.

Трансперэнси интернэшнл олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг авилгын индексээр Өмнөд солонгос 2012-2020 онуудад, өөрөөр хэлбэл 9 жилийн хугацаанд 53-61 оноо авч дэлхийд 30-33 дугаар байруудыг тус тус эзэлсэн байна.

Зураг 4. БНСУ-ын авилгын индекс



Фрийдом хаус байгууллагын хэвлэлийн эрх чөлөөний индексийн шалгаруулалтаар Өмнөд Солонгос Улс 23,43 оноо авч дэлхийн улс орнуудаас 42 дугаар байрт[18] бичигдэж хэвлэл мэдээллийн эрх чөлөө хязгаарлагдмал биш гэсэн ангилалд ордог аж. Энэ бүгдээс харахад Солонгос Улс ардчиллын үйл явц, эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдээрээ ч дэлхийн улс орнуудыг хошуучлан хөгжиж байгаа нь харагдаж байна.

Глобалчлал тус улсын эдийн засагт асар их эерэг үр дагавар авчирсан гэж үздэг. Эдийн засаг хэдий чинээ либералчилагдах тусам бүс нутгийн глобалчлалд нэгдэх үйл явц төдий чинээ хурдасна гэж эрдэмтэн судлаачид үздэг ажээ. Үүний тод жишээ нь: Өмнөд Солонгосын ДНБ-ний 66 хувийг гадаад худалдааны өсөлтөөр хангаж байгаа нь эдийн засаг хэр зэрэг глобалчлагдаж байгаагийн нэг илрэл юм. Өнөөдөр БНСУ 73 сая хүн амтай, эдийн засгийн хүчин чадлаараа дэлхийд 10 дугаарт ордог дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын нэг болжээ.

Г. Монгол Улсын хөгжлийн онцлог: 1990 оны өөрчлөлт шинэчлэлтийн үйл явц Монгол Улсын улс төр, нийгэм эдийн засгийн байдлыг үндсээр нь өөрчилсөн. Тухайлбал: Улс төрийн хувьд нэг намын дарангуйллын захиран тушаах хэлбэрээс, ардчилсан сонгуультай, олон намын тогтолцоотой болж, эдийн засгийн хувьд чөлөөт зах зээлийн эдийн засгийн харилцааг, нийгмийн хувьд хүн төвтэй хөгжлийн загварыг чухалчлан өнөөг хүртэл 30 гаруй жил хөгжиж ирлээ. 1992 онд шинэ үндсэн хуулиа баталж төрийн эрх барих ардчилсан дээд байгууллага болох УИХ-ыг бүх нийтийн шууд, чөлөөт ардчилсан сонгуулиар байгуулдаг болсон.

Энэ хугацаанд улс орноо хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны олон хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллажээ. Тухайлбал, 1996 онд УИХ-ын тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, 1996-2015”; 1998 онд Засгийн газрын тогтоолоор “Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг”, 2008 онд УИХ-ын тогтоолоор “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг”, 2016 онд УИХ-ын тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг, 2020 онд УИХ-н тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тус тус баталжээ.

Монгол Улс сүүлийн 30 жилийн хугацаанд ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлэх зорилгоор өмчийн олон хэлбэрийг хөхиүлэн дэмжиж (хувийн өмчийг), уул уурхайг түшиглэн улс орныхоо эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлого явуулсан.


Мөн уул уурхай, байгалийн баялагийн идэвхтэй ашиглалт, эдийн засгийн өндөр өсөлт гарсантай холбоотойгоор төрөөс хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын бодлогод халамжийн чиглэлүүдийг түлхүү хэрэгжүүлсэн байдаг. Ж: “2004 онд МАН шинээр төрсөн хүүхэд, шинэ гэр бүлийн тэтгэмжүүдийг, харин АН хүүхдийн “итгэлийн” мөнгийг амласан бол, 2008 онд дээрх 2 нам “Эх орны хишиг”, “Эрдэнийн хувь” зэрэг байгалийн баялгийг шууд хувиарлах амлалтууд өгсөн[19]. Энэ үеэс л нийгмийн хамгааллын бодлогын мөн чанар алдагдаж “Хавтгайрсан халамжийн бодлого” гэсэн нэршлийг олонтоо хэрэглэх болж, нөгөө талаар улс төрийн хүчнүүд засгийн эрхийг авахын тулд халамжийн бодлогыг ашиглан бэлэн мөнгө амлаж сонгуулийн хөтөлбөрүүдийг гаргах болсон. “2009 онд халамжийн зардал ДНБ-ний 3,2 хувь байсан бол 2010 онд 4,4 хувь, 2012 онд 6,7 хувьд хүрсэн байна[20]. Нийгмийн хамгааллын бодлого, зах зээлийн эдийн засгийн бодлогыг уялдуулалгүйгээр халамжийн чиглэлд ийнхүү бэлэн мөнгө тараах нь улсын төсөвт хүндрэл учруулахаас гадна төсвийн гол хэсгийг бүрдүүлдэг уул уурхайгаас олох ашиг буурч, гадаадын зээл тусламжийн хэмжээ нэмэгдэж өр өсдөг ба өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсөхөөс гадна, хамгийн эмзэг бөгөөд сөрөг асуудал нь олон нийт бэлэн мөнгөний халамжийн тогтолцоонд дасаж хөдөлмөр эрхлэх сонирхолгүй болдог байна.

Манай улсын хэмжээнд 1993 оноос 2020 он хүртэлх 27 жилийн хугацаанд ДНБ 227,7 тэрбумаас 26,6 их наяд төгрөг болж 116 дахин өссөн, эдийн засгийн өсөлт 1995 онд-3,2%, 2019 онд-3,803%, 1995 онд нэг хүнд ноогдох ДНБ 654,1 ам доллар байсан бол 2020 онд 4,127 ам доллар болж 6 дахин өссөн дүн харагдаж байна. Монгол Улсын эдийн засгийн албан ёсны үзүүлэлтээс харахад өнгөрсөн 30-аад жилийн хугацаанд улс орны эдийн засгийн чадавхи эрс дээшилсэн тоо баримт харагдаж байна.

Фрийдом хаус олон улсын байгууллагын хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол улс 28,97 оноогоор дэлхийн 180 орноос 68 дугаар байранд, иргэдийн улс төрийн эрхээр 48 оноо авч чөлөөтэй гэж үнэлэгдсэн байна. The Economist сэтгүүлийн 2020 оны Ардчиллын үнэлгээгээр 6,48 оноо авч гажуудсан ардчилалтай улс гэж тус тус дүгнэгджээ[21].

Монгол Улсын хөгжлийн онцлогт эдгээр нааштай алхамууд байгаа боловч нийгэм, эдийн засгийн тулгамдсан олон асуудал шийдвэрээ хүлээсээр байна. Жишээ нь: авлига, хүнд суртал, ажилгүйдэл, ядуурал, шударга ёс, нийгмийн баялагийн тэгш хуваарилалт, эдийн засаг бизнесийн хөгжилд улс төрийн оролцоо давамгайлсан гэх мэт олон асуудлууд хуримтлагдсан хэвээр байна. Монгол Улсын албан ёсны ядуурлын түвшин өнөөгийн байдлаар 30% - 33%. Трансперэнси интернэшнл олон улсын байгууллагын авилгын индексээр Монгол улс ойролцоогоор 35-39 оноотой дэлхийн улс оруудын хэмжээнд 72-111 дүгээр байрт жагсаажээ.

Зураг 5. Монгол Улсын авилгын индекс



Монгол Улс урт хугацааны бодлогын баримт бичгүүдийг боловсруулан улс орныхоо хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж ирсэн ч улс төрийн намууд тухайн үедээ урт хугацааны хөгжлийн бодлогоо зөвшилцдөггүй, бүх нийтээрээ хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гаргадаггүй, өөр улс төрийн намын үед баталсан хөгжлийн бодлогыг хүлээн зөвшөөрдөггүй, өөрсдийнхөөрөө өөрчилдөг, төрийн тогтвортой нэгдсэн бодлого байдаггүй зэрэг бэрхшээл дутагдлууд амь бөхтэй оршсоор байна. Нөгөө талаас тухайн үед хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль эрх зүйн орчин хангалтгүй, улс төрийн хүчнүүд өөрсдийн дураар төрөл бүрийн бодлого, хөтөлбөр гаргаж, төрийн бодлогын нэгдсэн, уламжлалт чанарыг алдагдуулж байжээ[22].

Дээрх байдлаас харахад анхны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталснаас хойш 25 жилийн хугацаанд 5 дахь хөгжлийн баримт бичгийг баталсан байна. Өөрөөр хэлбэл нэг бодлогын баримт бичгийн үйлчлэх хугацаа 5 жил байгаагаас харахад манай улсад улс орноо хөгжүүлэх хөгжлийн бодлого тогтворгүй, хэрэгжилт хангалтгүй, бодлогын уялдаа холбоогүй, тухайн асуудлыг нэгтгэж зангидах тодорхой бүтэцгүй явж ирсэн байна. Энэ асуудлыг нааштай шийдвэрлэх зорилгоор энэ онд буюу 2022 оны эхээр “Эдийн засаг хөгжлийн яам”-ыг шинээр байгуулан ажиллаж байгаа нь хамгийн зөв зүйтэй алхам болсон гэж үзэж байна.

IV. Дүгнэлт

Улс орнуудын хөгжлийн бодлогыг судлах, харьцуулан анализ дүгнэлт хийх зорилгоор ОХУ, Казакстан, Өмнөд Солонгос, Монгол зэрэг улс орнуудын хөгжлийн бодлогын талаар мэдээлэл цуглуулж баримт бичгийн судалгаа хийв.

ОХУ бол байгалийн хий, нефть олборлогч, экспортлогч гол орны нэг бөгөөд улс төрийн хувьд харьцангуй тогтвортой. Эдийн засгийн хүчин чадлаараа дэлхийд 11 дүгээрт ордог, Шинжлэх ухаан, боловсрол өндөр түвшинд хөгжсөн, цэрэг улс төрийн хувьд дэлхийн тэргүүлэгч гүрэн юм. Казакстан Улсын тухайд 1990 оноос шинэ тутам байгуулагдсан, газрын тос, нефтийн бүтээгдэхүүний асар их нөөцтэй, дэлхийн эдийн засгийн өрсөлдөх чадвартай шилдэг 50 улсын эгнээнд багтан орж, дэлхийн хамгийн эрчимтэй хөгжиж байгаа улсын нэгээр дэвшин орсон улс. Монгол Улсын тухайд байгалийн баялагийн асар их нөөцтэй, хүн ам цөөтэй, Азийн улс орнуудын дотроос Ардчиллыг шинээр буюу сэргээн хөгжүүлж байгаа улс орны тоонд

багтан ордог улс юм. Солонгосоос бусад орнууд нь 1990 оноос өмнө бүгд социалист системд багтаж тэр чиг баримжаагаар хөгжиж байсан, 1990 оноос хойш өрнөсөн өөрчлөлт шинэчлэлийн үр дүнд улс төр, нийгэм эдийн засгийн реформ хийн өөр өөрсдийн хөгжлийн замналаар хөгжиж байгаа улс орнууд юм.

ОХУ, Казакстан улсуудын тухайд хөгжлийн бодлого, улс төр нь харьцангуй тогтвортой явж ирсэн учраас нийгэм-эдийн засгийн хувьд олсон ололт амжилт, үр дүн харьцангуй өндөр байна. Харин ардчилал, хүний эрхийн талаар олон улсын байгууллагуудын үнэлгээ шалгаруулалтаар, дэлхийн улс орнуудын хэмжээнд нилээд хойгуур үзүүлэлттэй байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл шударга сонгуулийн систем, улс төрийн нөлөөллөөс хараат бус хууль, шүүхийн тогтолцоо, чөлөөт хэвлэл мэдээлэл, авилгын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд төдийлөн амжилттай биш ажээ. Тухайлбал: 2022 оны эхээр Казакстан улсад болсон олныг хамарсан эмх замбараагүй үйл явдал нь улс орныхоо дотоодод хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанд, түүн дотроо олигархижсан төрийн бодлогыг эсэргүүцсэн ард түмний тэмцэл байсан гэж ойлгогдож байна. Энэ үйл явдлын дараа Казакстан Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев улс орондоо улс төрийн системийн шинэчлэл хийх гэж байгаагаа мэдэгдээд байна. Үүний хамгийн эхний алхам нь 2022 оны намар Казакстан Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг хугацаанаас нь өмнө зохион байгуулах ба Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 7 жил байх ба зөвхөн 1 удаа сонгогдохоор санал оруулсан байна. Энэ нь төрийн эрх мэдлийг монополь болгохоос урьдчилан сэргийлж байгаа алхам гэж үзжээ.

Өмнөд Солонгос улсын хөгжлийн хүрсэн түвшин бол гайхамшиг. Асар богино хугацаанд, өөрөөр хэлбэл 40 хүрэхгүй жилийн хугацаанд цэргийн хатуу дэглэмийн нөхцөлд, зах зээлийн эдийн засгийн ул суурьтай, ухаалаг, тууштай бодлого хэрэгжүүлснээр том амжилтанд хүрсэн. Үүнд: 1. Улс орныхоо хөгжил, эдийн засгийн чадавхийг сайжруулахын тулд төрийн бодлогыг маш ухаалаг, төлөвлөлттэй, тооцоо судалгаатай, алсын хараатай хэрэгжүүлсэн. 2. Улсын эдийн засгийн бодлого нь улс төр, бизнесийн сонирхлоос ангид явж ирсэн. 3. Гадаадын хөрөнгө оруулалтыг хатуу хуваарилалтын зарчим баримтлан ажилласан. 4. Солонгосын ард түмний ажилсаг, хичээнгүй зүтгэл, сахилга бат, зохион байгуулалт, эх орноо гэсэн үндэсний үзэл маш чухал нөлөөлсөн гэж үзэж байна.

Монгол Улсын тухайд хөгжлийн бодлого төлөвлөлт тогтвортой биш (анхны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталснаас хойш 25 жилийн хугацаанд 5 дахь хөгжлийн баримт бичгийг баталсан), байгалийн баялаг, уул уурхайгаас хэт хараат эдийн засагтай, үйлдвэрлэл сул хөгжсөн, импортоос хэт хамааралтай, ажилгүйдэл, ядуурал ихтэй, байн байн өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт бий болдог гэх мэт олон тулгамдсан асуудал хуримтлагдсан. Мөн улс төрийн тогтворгүй байдал нь улс орны хөгжилд сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал: 1990 оноос өнөөг хүртэл 32 жилд 17 Ерөнхий сайд ажилласан ба дунджаар 1,2 жилийн настай Засгийн газрууд оршин тогтнож байжээ. Мөн парламентийн сонгуулийн 4 жилийн циклээс улс орны амьдрал бүхэлдээ хамааралтай явж ирсэн нь улс орны хөгжлийг саармагжуулж буй гол алдаа гэж хардаг. Тийм учраас бид өөрсдийн хөрш зэргэлдээ улс орнууд болон бусад амжилттай хөгжиж буй улс орнуудын хөгжлийн ололт амжилтаас суралцах,

судлах асуудал нэн чухал байна. Өнөөдөр Монголын нийгэмд бүхэлдээ оюун санаа, хүмүүжил, ёс суртахуун, удирдлага, зохион байгуулалтын задралын процесс хүчтэй өрнөж байгаа тул үндэсний үзэл, үндэсний ухамсар, эх оронч үзлээр иргэд, хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэх, нэгтгэн зангидах ажлыг бүх түвшиндээ анхаарах цаг нэгэнт ирсэн байна. Нэн тэргүүнд иргэдийн үндэсний ухамсарыг нэгтгэн зангидсан төрийн бодлого үгүйлэгдэж байна. Үүний дараа эдийн засаг, нийгмийн хөгжлийн олон асуудал эмх цэгцэндээ орж, амжилтанд хүрэх үүд хаалга нээгдэх болно.

Доорх графикуудаас харахад бидний судалгаа хийсэн 4 улсын хөгжлийн ерөнхий багцаа маш тодорхой харагдаж байна. Нэг хүнд ноогдох ДНБ-ийг улс бүрээр нь харуулсан график.

Зураг 6. Нэг хүнд ногдох ДНБ хэмжээний харьцуулсан график



Эдгээр харьцуулсан судалгааны материалаас харахад тухайн улс орны улс төр, хөгжлийн бодлого тогтвортой, онцлог нөхцөл байдалд тохирсон мөн улс орны хөгжлийн бодлого нь улс төр, бизнесийн сонирхлын бүлгээс ангид байвал улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил амжилттай байж улсын хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлдэг болох нь батлагдаж байна. Мөн хөгжлийн алтан гурвалжин гэж үздэг нийгмийн тэгш байдал алдагдвал улсын хөгжлөөс байнга арагш чангааж байдаг аж. Өөрөөр хэлбэл энд хийсэн судалгаагаар Солонгос Улсын хөгжил бүх үзүүлэлтүүдээр манлайлж байгаа нь харагдаж байна.

Зураг 7. Авлигын индексийн харьцуулсан график



Дэлхийн улс орнуудын хөгжлийн бодлого, онцлогийн тухай бичсэн, харьцуулсан анализ дүгнэлт хийсэн эрдэм шинжилгээний бүтээлүүд харьцангуй олон байдаг. Харин Монгол Улсын хөгжлийн онцлог, хөгжлийн бодлого хэрхэн явж ирсэн, ямар үр дүнд хүрч, ямар бэрхшээл тулгарч, ямар алдаа оноо байгааг хөрш зэргэлдээ улс орнуудтай болон Азийн харьцангуй өндөр хөгжилтэй улс орнуудтай харьцуулан анализ дүгнэлт хийсэн судалгааны ажил өнөөдрийн байдлаар цөөхөн байдаг ба энэ удаад ингэж харьцуулан дүн шинжилгээ хийснээрээ ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Ашигласан материал

1. УИХТГ. (2014). Дэлхийн хөгжлөөрөө тэргүүлэгч зарим орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга, туршлага. Харьцуулсан судалгаа СТ-13/239. Уб.,
2. Дэмбэрэл Д. (2006). ОХУ-ын “Үндэсний хөтөлбөрүүд” нийгмийн тулгамдсан асуудлыг шийдэх нэг алхам болох нь. Олон улс судлал. №1. 43 дахь тал
3. <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD?locations=RU> -ээс дэлгэрүүлэн үзнэ үү.
4. <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.DEFL.KD.ZG?locations=RU> -ээс дэлгэрүүлэн үзнэ үү.
5. <https://ratendel.com/economics/bednost-rossiya-statistika> -ээс дэлгэрүүлэн үзнэ үү.
6. Transparency International. <https://transparency.mn/post/2020/> -ээс дэлгэрүүлэн үзнэ үү.
7. Freedom house. <https://freedomhouse.org/report/freedom-and-media/2019/media-freedom-downward-spiral-ээс> дэлгэрүүлэн үзнэ үү.
8. <https://solability.com/the-global-sustainable-com/index/governance-capital> -ээс дэлгэрүүлэн үзнэ үү.
9. Нурсултан Назарбаев. (2010). “Казахстаны замнал”. Уб., 13 дахь тал
10. <https://gogo.mn/r/x333j>.Х.Кегершин. Казахстаны хөгжлийн түлхүүр. 2016-06-24
11. Закон.kz. (2021). Социальная политика Казахстана: Успехи и достижения за годы независимости: 2021.12.15

12. <https://solability.com/the-global-sustainable-com/index/governance-capital-ээ> дэлгэрүүлэн үзнэ үү
13. Freedom house. <https://freedomhouse.org/countries/freedom-net.scores-ээс> дэлгэрүүлэн үзнэ үү.
14. Mancur Olson, “The rise and Decline of Nations; Economic growth, stagflation and social rigidities in New Haven”
15. World Bank. <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.DEFL.KD.ZG?locations=KR> -ээс дэлгэрүүлэн үзнэ үү.
16. <https://solability.com/the-global-sustainable-com/index/governance-capital-ээс> дэлгэрүүлэн үзнэ үү.
17. <https://solability.com/the-global-sustainable-com/index/governance-capital-ээс> үзнэ үү.
18. Freedom house. <https://freedomhouse.org/countries/freedom-net.scores-ээс> дэлгэрүүлэн үзнэ үү.
19. Түмэннаст Г. (2019). Нийгмийн социаль хүрээний өөрчлөлт, асуудал. Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт. /1990-2019/. pp. 240-271. Уб., Адмон принт. 247 дахь тал.
20. Түмэннаст Г. (2019). Нийгмийн социаль хүрээний өөрчлөлт, асуудал. Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт. /1990-2019/. pp. 240-271. Уб., Адмон принт. 247 дахь тал.
21. <https://solability.com/the-global-sustainable-com/index/governance-capital-ээс> үзнэ үү.
22. Үндэсний хөгжлийн газар. (2018). Монгол Улсын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ. Уб., 13 дахь тал

Санхүүжилт: Энэхүү ажлыг гүйцэтгэхэд тусгайлсан санхүүжилт гараагүй болно.

Талархал: Тухайн бүтээлийг бичиж боловсруулахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн Улс төр, эрх зүйн салбарын хамт олондоо талархал илэрхийлж цаашдын эрдэм номын их ажилд нь өндөр амжилт хүсэн ёрөө!